

**ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТАМГЫН ГАЗРЫНҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

/2010 оны үйл ажиллагааны үр дүн/

№	Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
			хувь	оноо
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	93.2	4.6
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	93.6	4.6
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	83.4	4.1
Үнэлгээний дундаж оноо			90.0	4.4
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	95.9	4.7
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	93.7	4.6
		3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	100.0	5.0
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	91.9	4.5
Үнэлгээний дундаж оноо			95.3	4.7
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	93.6	4.6
		2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	94.6	4.7
Үнэлгээний дундаж оноо			94.1	4.6
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	93.3	4.6
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	90.0	4.5
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	97.0	4.8
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	95.0	4.7
Үнэлгээний дундаж оноо			93.8	4.6
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	96.7	4.8
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	72.7	3.6
Үнэлгээний дундаж оноо			84.7	4.2
Ерөнхий үнэлгээ			91.5	4.5

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

**ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА Ц.ЖАНЛАВ**

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Монгол улсын Засгийн газраас 2010 оныг “Бизнесийн шинэтгэлийн жил” болгон зарласны дагуу орон нутагт дараах ажлуудыг зохион байгууллаа.

Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд оны эхэнд жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид, банк, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон “Орон нутгийн тулгамдсан асуудал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийн 2 үе шаттайгаар зохион байгууллаа. **Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхим, Бизнес инкубатор төв, Хөгжлийн шийдэл зэрэг төрийн бус байгууллагуудаас санаачлан бизнес эрхлэгчдийг дэмжсэн, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилсан үзэсгэлэн худалдаа, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээнүүдийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж манай аймгийн бизнес эрхлэгчид энэ төрлийн арга хэмжээнд идэвхитэй оролцдог боллоо.**



Төр-иргэний харилцан илтгэлцлийг үргэж, төрийн захиргааны байгууллагын ажлын чанарт ахиц гаргаж, иргэдийн сэтгэлгээнд шинэ хандлага тогтоох, мэдээллийн технологийн ололтыг ашиглах, т үйлчилгээг ард иргэдэд шуурхай үргэх хүрээнд нилээд ажлуудыг зохион байгууллаа. 2010 онд үргэсэн зорилтын үрээнд х **“Иргэдтэй уулзах өдөр”**-ийн арга хэмжээг баг бүрт

болон телевизийн шууд ярилцлага хэлбэрээр 9 удаа зохион байгуулж аймгийн Засаг даргын дэргэдэх 20 агентлаг оролцож, нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх, иргэдийн санал хүсэлтийг сонсох, сонирхсон асуултад хариулах зэргээр төрийн үйлчилгээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн талаар мэдээлэл хийж давхардсан тоогоор 10 мянга гаруй иргэн хамрагдаж 2500 санал,



хүсэлт, зөвлөмж, өргөдөл хүлээн авч хариу өгсөн байна.


Засгийн газрын тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар тус аймагт “Нэг цонхны үйлчилгээ”-г 9 үдээр сар аас нээн ажиллуулж аймгийн Засаг даргын дэргэдэх 6 агентлаг үйл ажиллагаагаа явуулж, нэг цэгээс төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж эхэллээ. Нэг цонхны үйлчилгээг нээн ажиллуулснаас хойш давхардсан тоогоор 14116 иргэнд үйлчилсэн байна.



Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоолын дагуу жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдөр “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР”-ийн арга хэмжээг аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагууд, аймаг, сумын Засаг даргын Тамгын газраас хамтран иргэдийн санал хүсэлт, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд тусгуулах санал, зөвлөмжийг сонсож, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, алдаа дутагдлыг иргэдийн нүдээр харж засаж залруулах зорилгоор зохион байгуулж үе дөрлөгийн арга хэмжээнд 2808 иргэдэд үйлчилгээ үзүүлсэн бөгөөд байгууллага албан тушаалтнууд саналын хайрцаг болон амаар нийт 2212 санал хүсэлт хүлээн авч зохих хэсгийг газар дээр нь шийдвэрлэн хариуг өгч ажиллалаа.



2010 онд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, ажлын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 7 хоног бүрийн даваа гарагт төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдах ажилтнуудын **Шуурхай** хуралдааныг зохион байгуулж хэвшсэн билээ. Энэ онд 47 удаа



шуурхай хуралдаан хийж 26 удаагийн хуралдааны тэмдэглэлээр 44 үүрэг даалгаврыг албажуулан холбогдох агентлагуудын удирдлага, албан тушаалтнуудад өгч биелэлт **91 хувьтай** гарлаа. Шуурхай хуралдаанаар өгсөн үүргийг хангалтгүй биелүүлсэн 6 албан тушаалтанд аймгийн Засаг даргын захирамжаар сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Төрийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд чирэгдэлгүй

хүргэх, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөөгийн 13 сумыг шеф болгон хариуцуулж цаг үеийн болоод төлөвлөгдсөн ажил арга хэмжээг хамтран зохион байгуулж хэвшлээ.



төгрөгийн хөрөнгө оруулалтын хийж аймгийн 4 багт мэдээллийн танхим, 10 багт компьютер олголоо. Аймгийн тэргүүний баг шалгаруулах болзолт уралдааныг зарлан 6 багийг

шалгаруулан 3 сая төгрөгөөр урамшууллаа. 2 баг шинээр ажлын албаны байртай боллоо. Хэрлэн сумын 10 баг интернэт сүлжээнд холбогдлоо.

Тогтвортой амьжиргаа төслийн дэмжлэгийг багийн хөгжилд хандуулан 1,2,4 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай, 2 дугаар багт усан сан, 3, 9 дүгээр багт чийрэгжүүлэлтийн болон чөлөөт цагийн танхим, 10 дугаар багт хогны машин авах зэрэг

хөрөнгө оруулалтууд хийлээ.

Дорнод аймаг нь ОХУ-ын Чита мужийнӨвөр байгалийн хязгаар, БНХАУ-ын Хөлөнбуйр хот, Манжуур хот, Хянган аймагтай уламжлалт харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэхийн зэрэгцээ сүүлийн жилүүдэд БНСУ-ын Пучонь хот, БНХАУ-ын Жилин муж, өмХ хот, Шилийн гол аймагтай нөхөрсөг харилцаа тогтоож, хамтын ажиллагааны



шинэ шатанд орж, мөн Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбооны гишүүнчлэлээр элсэн орж идэвхтэй хамтран ажиллаж байна.



Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн “Хөгжлийн цогц бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын

хүрээнд Дорнод аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу Засгийн газрын 2007 оны 69 дүгээр тогтоолоор Чойбалсан-Хайлаарын чиглэлийн олон улсын агаарын нислэгийг 2010 оны 3 дугаар сараас эхлэн 7 хоногт 2 удаа үйлддэг боллоо.



Хоёр талын гэрээний дагуу боловсролын салбарт ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын амбан захирагчийн тэтгэлгээр Чита хотын их дээд сургуульд жил бүр 5-10 оюутан, БНХАУ-ын Хянган аймаг, Хөлөнбуйр хотод харилцан 10 оюутан сургаж байна.



Гадаадын хөрөнгө оруулалтаар Чойбалсан хотод ОХУ-ын Чита муж, Агын нэрэмжит гудамж байгуулсан ба Монгол, Хятад хоёр орны Засгийн газрын шийдвэр, Дорнод аймаг, Хөлөнбуйр хотын хамтын ажиллагааны үр дүнд улирлын чанартай нээн ажиллаж байсан Хавирга-Архашаатын боомт уртасгасан хугацаатай ажиллах болсон.

Баянхошуу-Өвдөгийн боомтын Халх голын гүүрийг Хятадын талын хөрөнгөөр бариулах ажил амжилттай болсон. БНХАУ-ын Хянган аймгийн Аршаан хотын хөрөнгө оруулалтаар Монгол-Хятадын хилийн Нөмрөгийн голын гүүр баригдаж, одоо боомтын барилгын ажил явагдаж байна. БНХАУ-ын Хөлөнбуйр хотын Шинэ Барга баруун хошууны хөрөнгийн тусламжтайгаар Монгол-Хятадын хилийн Хавиргын боомтын байранд иж бүрэн засвар хийгдлээ. Зүүн хойд Азийн Хүүхэд, эмэгтэйчүүдийн нийгэмлэгийн салбар



хороог Монгол улсад анх удаа Дорнод аймагт байгуулсан нь Хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн олон улсын арга хэмжээг зохион байгуулж, аймаг орон нутгаа Зүүн хойд Азийн улс орнуудад таниулах, нийгэм, эдийн засгаа хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа боллоо.

Хууль, эрх зүйн хүрээнд:



Улсын хэмжээнд явагдсан иргэний шинэчилсэн бүртгэлийн ажил манай аймгийн хэмжээнд 90.3 хувьтай байгаа бол, 10 жил тутам зохион байгуулагддаг хүн ам, орон сууцны тооллого 11 дүгээр сарын 11-17ны өдрүүдэд амжилттай явагдаж өөр аймаг, хот, гадаад улсад сурч ажиллаж, амьдарч байгаа буюу түр эзгүй иргэд ороогүй урьдчилсан дүнгээр 69140 хүн тоологдлоо.

Аймгийн хэмжээнд 2010 оны байдлаар 526 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 18,5 хувь, 115 пунктээр буурсан байна. Үүнээс дараах тодорхой төрлийн гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал: Бусдын өмчийг хулгайлах гэмт хэрэг 24,6 хувь /60 пунктээр/, иргэдийн өмчийг хулгайлах хэрэг 22,4 хувь /25 пунктээр/, мал хулгайлах гэмт хэрэг 46,1 хувь /59 пунктээр/, танхайрах гэмт хэрэг 8,9 хувь /6 пунктээр/, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг 47,3 хувь /17 пунктээр/ буурсан байна.

Аймгийн Засаг даргыг ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс Цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэс дараатай арга хэмжээ авч зохихүр дүнд хүрч байна.

2010 онд аймгийн хэмжээнд цагдаагийн ажиллах, амьдрах өхцөлийг нэг дор бүрдүүлсэн кабон 5 суманд шинээр баригдаж эдгээр сумын цагдаагийн ажилтнуудын ажиллах, амьдрах нөхцөл эрс дээшиллээ.



Мөн дээрх хугацаанд цагдаагийн ажилтнуудын албан ажлын хэрэгцээнд 1 машин шинээр авч парк шинэчлэл хийсэн байна. Дорнод аймгийн Цагдаагийн газар нь байнгын радио холбоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд мэдээлэл шуурхай солилцох зорилгоор 14 сумын хэсгийг өлөөлөгчдийг "Жи Мобайл"

сүлжээний утас, суурин станцаар хангаад байгаа аж.

Засгийн газрын 2006 оны 64 үдээр тогтоолоор баталсан “Төрийн архив, албан хэрэг өтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийг орчин үеийн техник хэрэгслээр хангах үүднээс 2010 онд 5.5 сая төгрөгийн тоног төхөөрмжөөр хангалаа.



Аймгийн хэмжээнд Авлигатай тэмцэх, мэдээлэл сургалт сурталчилгааг эрчимлэх зорилгоор орон нутгийн үйл ажиллагаанд 3.0 сая төгрөгийг дэмжлэг үзүүллээ. Энэ ажлын хүрээнд Авлигат ай тэмцэх газраас мэргэжилтэнг урьжүүлэн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Цагдаагийн газар, ЕБС-ийн удирдлага, багш нартай хамтран “Цахим тоглоом”-ын газруудад хяналт шалгалтыг хийж гарсан нийтлэг зөрчлүүдийн талаар эргэн сануулж, журам болон цагийн хуваарийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг үүрэг болголоо.



Санхүү, төсвийн бодлогын хүрээнд:



Орон нутгийн төсвийн тэнцэл 2010 онд төлөвлөсөн хэмжээнээс 2.5 хувиар буюу 108.6 сая төгрөгөөр сайжирснаар төсвийн тэнцлийг төлөвлөсөн хэмжээнээс 0.2 хувиар сайжруулах талаар аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд

хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилтыг 12.5 дахин давуулан биелүүллээ

Хөрөнгө оруулалтын ажлын талаар Дорнод аймагт 2010 онд нийт 4 тэрбум 306.1 сая төгрөгийн 59 нэр төрлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжлээ. Мөн аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу орон нутгийн төсвийн тодотголоор 39.5 сая төгрөгийн 5 нэр төрлийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нэмж батлагдан хэрэгжлээ. Үүнд: 3.5 тэр бум төгрөгийн 22 нэр төрлийн төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулах журмаар, 600 сая төгрөгийн 32 нэр төрлийн төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 10,6 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулж ажиллалаа.



Татвар төлөгчдийн баазыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тайлант хугацаанд 68 хуулийн этгээдийг шинээр бүртгэснээр татвар төлөгчдийн тоог 6.7 хувиар өсгөж, аймгийн хэмжээнд 966 аж ахуйн нэгж, байгууллага 18863 татвар төлөгч иргэдэд татварын үйлчилгээг үзүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2009, 2010 оны эхний хагас жилийн тайлангаар нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох босгонд хүрсэн 20 аж ахуйн нэгжийг нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр шинээр бүртгэж 11.4 хувиар НӨАТатвар төлөгчдийн тоог нэмэгдүүлсэн байна.

Хөгжлийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн газраас 2010 онд үндсэн зорилт болон Дорнод аймгийн хөгжлийн хэтийн төлөв, байдал, гарцыг тодорхойлсон “ аймгийн Хөгжлийн цогц бодлого” баримт бичгийн боловсруулан хэрэгжүүлж, 2010 онд Монгол улсын Засгийн газраас “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас “Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, дэд бүтэц, үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах, хамгаалах ажлыг зохион байгуулах зорилго дэвшүүлэн ажиллаа.



Аймгийн Засаг даргын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ард, иргэд, хүүхэд залуусын амралт, өлөөлт цагаа өнгө рүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Цэцэрлэгт хүрээлэн”-гийн загвар эскиз, энэ жил төсөвлөгдсөн ажлын зураг, төсвийг ШУТИС-ийн архитектурын тэнхимийн дэргэдэх архитектурын багтай хамтран бэлтгэлээ

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Чацаргана” хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх **“Чацаргана” дэд** хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлууллаа. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХААХҮЯамнаас зарласан “Чацарганы суулгац зээлээр олгох” төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 3 аж ахуйн нэгж, 2 иргэний 5 төслийг шалгаруулан ХХААХҮЯаманд хүргүүлснээс нийт 7000 ш суулгацыг 5 жилийн хугацаатайгаар хүүгүй зээлээр худалдан авч тариалсан бөгөөд үүний үр дүнд жимс, жимсгэний тариалан эрхлэлт 5.8 га талбайгаар нэмэгдсэн байна.



Жижиг дундүйдвэрэлэийг дэмжих төслийн хүрээнд аймгийн хэмжээнд 111 төсөл 1,050.0 сая төгрөгийн санхүүжилт олгон үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ ажлын үрээнд ш инээр 4 үйлдвэр ашиглалтанд орж хөнгөлөлттэй зээлийн үр дүнд 234 ажлын байр хадгалагдан үлдэж 215 ажлын байр шинээр бий болж үйлдвэрлэл эрхлэгчдэд бодит дэмжлэг болж байна.



“Сүү” дэд хөтөлбөрийг боловсуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 08 сарын 06 өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав. Аймгийн төв орчмын фермерүүдэд сүүний өндөр ашиг шимт үхрийн жинг нэмэгдүүлэх зорилгоор 2009 онд 18 аж ахуй нэгж, иргэний 59 үхэрт зохиомол хээлтүүлэг хийснээс одоогоор 11 хувь тугалаад байна.

Энэ онд 12 аж ахуй нэгж иргэдийн 52 үхэрт мах, сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн үхрийн тоо, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор Лимузин, Талын улаан, Семминталь, Хар тарлан, үүлдрийн үхрийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн. ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлэнд төсөл шалгаруулах комиссоос туслах аж ахуй болон сүүний фермер байгуулах, өргөтгөх чиглэлтэй 17 төсөл дэмжигдэн 165.9 сая төгрөгийн санхүүжилт аваад байна. Энэ төслүүд дэмжигдснээр нийт 52 ажлын байр шинээр бий боллоо.

Дорнод аймаг 2009 онд 73.5 мянган тн байгалийн хадлан авч төлөвлөгөөг 133.6



хувиар, 2010 онд **63.4 мянган тн** байгалийн хадлан авч төлөвлөгөөг **126.8** хувиар биелүүлээд байна. Бэлтгэсэн хадлангийн 54.9 мянган тн дотоодын хэрэгцээнд, 7.3 мянган тн бизнесийн чиглэлээр, 1.1 мянган тн нөөцлөх зорилгоор бэлтгэсэн. Монгол улсын засгийн газрын 2010 оны 166-р тогтоолын дагуу аймаг сумдад өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх зорилгоор аймгийн төсвөөс хувиарлаж өгсөн 36 сая төгрөгөөр 12 сумд тус бүр 30 тн, нийт 350 тн өвс бэлтгэн нөөцөлсөн ба 13 сум дотоод нөөц бололцоогоо ашиглан 708 тн өвс бэлтгэн 1058 тн, Аймгийн мал хамгаалах сангийн хүрээнд байгуулсан 3 хадлангийн механикжсан салаа 141.2 тн өвс нийт аймгийн хэмжээнд 1.2 мянган тн өвсийг аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлж чадсанаар өвлийг өнөтөй сайхан давлаа.

Энэ онд улсын төсвийн 243.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг 14 суманд шинээр гаргаж эзэмшигчдэд актаар хүлээлгэн өглөө. Шинээр худаг гаргуулах хүсэлт гаргасан 60 цэгт усны хайгуулын геофизикийн судалгааг хийлээ. Мөн 2010 онд “Тогтвортой амжиргаа 2” төслөөр 32 худгийг 32,752,900 төгрөгийн өртөгтэйгээр шинээр гаргаж, 13,069,900 өртөгтэйгээр 21 худгийг сэргээн засварлаад байна.



Жил бүр зохион явуулдаг “Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл-2010” үзэсгэлэн худалдааг “Эрүүл хүнс, эрүүл мэнд” уриан дор зохион явуулсан бөгөөд үзэсгэлэн худалдаанд хүнс үйлдвэрлэгч, хүнсний ногоо тариалагч 44 аж ахуй нэгж, иргэн оролцож 4

сая орчим төгрөгний борлуулалтыг хийж, 2000 орчим иргэдэд үйлчилсэн байна.

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны “Койка” байгууллагын санхүүжилтээр “Халхголын бүс нутагт хөдөө аж ахуйг сэргээн хөгжүүлэх” төслийн эхний шатанд 200 га-гийн мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар фермерийн аж ахуй байгуулах ажлын эхний үе шат хэрэгжиж 200 га-д уринш хийгээд байна.

Мөн Баянтүмэн суманд 1 аж ахуй нэгж 10 га-гийн, Хэрлэн суманд Дорнод бүсийн ЭШҮТөв 80 га-гийн, Онхоодой-Өндөр ХХК 10 га-гийн услалтын системийг барьж байгуулаад байна.



Аймгийн хэмжээнд атаршсан талбайг сэргээн ашиглахад Үр тарианы 4 аж ахуйн нэгжүүд голлон ажиллаж 3970 га-д улаан буудай, 50 га-д гурвалжин будаа тариалснаас Улаанбуудай 5074 тн, Гурвалжин будаа 45 тн-ыг хураан авсан бөгөөд атаршиж өнжөөсөн талбайгаас 5400 га талбайг нэмж ашиглан 8400 га талбайд уринш бэлтгэн нь өмнөх оныхоос 6300 га-гаар буюу 4.0 дахин өссөн

үзүүлэлт боллоо.

Дэд бүтэц, барилга хот байгуулалт, аялал жуулчлалын чиглэлээр:

Чойбалсан хотын Нисэх онгоцны буудлын чиглэлд 0.97 км хатуу хучилттай зам, хуучин Нисэхийн замыг үргэлжлүүлэн 0.87 км замын барилга угсралтын ажлыг бүрэн хийж дуусгаад улсын комисст хүлээлгэн өглөө.



2010 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 200.0 сая төгрөгийн хүрээнд Халхгол сумын Ялалт багаас Загасчдын хотхон, Буйрын застав хүртэл

29 км, 15 кВ-ын ЦДАШ, дэд станц барих ажлыг гүйцэтгэж дуусаад ашиглалтад хүлээлгэн өглөө.

Хэрлэн сумын хотын төвөөс алслагдсан 5 дугаар багийн нутаг дэвсгэрийн айл өрхүүдийн цахилгаан хангамжийн чанарыг сайжруулах, сүлжээг өргөтгөх ажлыг улсын төсвийн 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулсан.

Чойбалсан хотын төв Радвангийн гудамжнаас төмөр замын Баянтүмэн тасаг хүртэл шинээр тавигдсан хатуу хучилттай замын дагуу 1.5 км гэрэлтүүлэг шинээр хийх ажлыг орон нутгийн төсвийн 36.0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтанд оруулсан бөгөөд хотын өнгө үзэмж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан ажил болсон.



Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотод 2010 онд цэцэрлэгт хүрээлэн, парк байгуулах ажил төлөвлөгдөж аймгийн ЗДТГазрын хойт талд цэцэрлэгт хүрээлэн байгуулах талбайд БНХАУ-ын Хайлаар хотын хөрөнгө, дэмжлэгээр усан оргилуур байгуулж, орчин тойронд хашаажуулах, гэрэлтүүлэг суурилуулах ажлыг улсын төсвийн 50,0 сая төгрөгөөр хийлээ.

Аймгийн төвийн Хэрлэн сумын гэр хорооллын иргэдийн усан хангамжийн хүрэлцээг сайжруулах зорилгоор өнгөрсөн 2 жилд 7 усан санг төвийн шугамд холбосноор, хотын хэмжээнд 17 худаг, 16 усан сан ажиллаж байна. Мөн “Тогтвортой амьжиргаа II” төслийн олон нийтийн санаачлагыг дэмжих сангаас 6261.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэн 2 дугаар багийн “Тээвэрчид”-ийн гудамжинд шинээр 1 усан сан барьж ашиглалтад орууллаа.



Аялал жуулчлалын хүрээнд:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд Хил орчмын аялал жуулчлал хөгжүүлэх талаар онцгой анхаарч,

холбогдох арга хэмжээ авч ажиллана гэсэн зорилтын хүрээнд “Хөрш зэргэлдээ 3 улсын аялал жуулчлалын өдөр” арга хэмжээг анх удаа 6 дугаар сард Дорнод аймагт зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд “Хөрш зэргэлдээ 3 улс болон зүүн бүсэд аялал жуулчлал хөгжүүлэх боломж” сэдэвт онол практикийн бага хурал, Монгол туургатны үндэсний хувцасны баяр, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот, Сүхбаатар, Дорнод аймгийн бизнес эрхлэгчид оролцсон үзэсгэлэн худалдаа, барга түмний соёл урлагын наадам зэрэг томоохон арга хэмжээнүүд болсон ба ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот, БОАЖЯамны дэргэдэх Аялал жуулчлалын үндэсний төв, Хэнтий, Сүхбаатар аймгийн 700 гаруй төлөөлөгчид оролцлоо.

Хөрш зэргэлдээ Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн Хязгаарын нийслэл Чита хотод **Чойбалсан хотын соёлын өдрүүд** 2010 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Соёлын өдрүүдийн арга хэмжээнд аймгийн удирдлагууд болон Чойбалсан хотын захирагч тэргүүтэй төлөөлөгчид, 25 хүнтэй урлаг, уран сайхны хамтлаг, нийт 30-нх Чита хотноо хүрэлцэн очиж, Монголын урлаг соёлыг хилийн чанадад сурталчиллаа.



Байгаль орчин, уул уурхайн чиглэлээр:

Байгалт орчин аялал жуулчлалын яамны Ойн газрын санхүүгийн дэмжлэгээр Баян-Уул сум дахь Сум дундын ойн ангийн дэргэд 5 га газарт мод үржүүлгийн газар, “Бавж барас” ХХК-ийн мод үржүүлгийн 0.5 га талбай, “Өвөр–Эрээн” ХХК-ны 5 га мод үржүүлгийн газарт 1-4 насны 1.547.981 ширхэг шинэс нарсны тарьц суулгац ил талбайд тарьсан байна.



Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тундас нэмэгдүүлэхээр 2010 онд Улаанбаатар хот дахь “Хурын шим” төвөөс экспедицийн тоног төхөөрөмжийг 599974 төгрөг, дагалдах JPJ-1A пуужин 60 ширхэгийг/1 пуужин 104652 төгрөг/ 6279120 төгрөгөөр худалдан авч ажиллуулаа. Үйл ажиллагааны зардалд 2.7 сая төгрөг зарцуулж орон нутгийн төсвөөр шийдвэрлэсэн бөгөөд үүл

буудаж 6 сарын сүүлээр бороо орох нөхцөл бүрдэж цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг нийт 7 удаа явуулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарилгийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар “Нэг байгууллага-нэг төгөл”, нэг төгсөгч-нэг мод”, “Өрх бүр жимсний мод тарья” хөдөлгөөн өрнүүллээ. Үүний дүнд Чойбалсан хотын хэмжээнд 89 аж ахуйн нэгж байгууллага 20500 хүн хамрагдаж 21353 ширхэг мод, бут тарьж ургуулсан байна. Тус аянуудын хүрээнд аймгийн хэмжээгээр нийтдээ 217 аж ахуйн нэгж байгууллага, 32482 иргэн оролцож 31 төрлийн 42481 ширхэг мод сөөг тарьж, 35 га талбайд зүлэгжүүлэлт, цэцгийн мандал 158-ийг байгуулж арчлан ургуулж байна. Нэгтгэсэн дүнгээр энэ ажилд 39.2 сая төгрөг зарцууллаа.



2010 онд Ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр 14 аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж техникийн нөхөн сэргээлт 54.3 га, биологийн нөхөн сэргээлт 14.2 га-г хүлээлгэн өгсөн байна.

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсрол, соёлын талаар:

БСШУ-ны сайдын багцад тусгагдсан Булган сумын ЕБС-ийн өргөтгөл 12м*18м харьцаатай спорт заалны барилга угсралтын ажлыг “Аригүн” ХХК зураг төсвийн



дагуу 235 сая төгрөгөөр гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгч, Булган сумын сурагчид зориулалтын спорт зааланд хичээллэх боломжоор бүрэн хангагдлаа.



2010 онд сум бүрт 2-оос доошгүй гэр цэцэрлэг ажиллаж хамран сургалтын хувь бохир жингээр 74%, цэвэр жингээр 65.4% болж өнгөрсөн хичээлийн жилээс 0.1% өссөн. 2010 онд хувилбарт сургалтаар 14 суманд 18 гэр цэцэрлэг ажилласан нь өнгөрсөн оныхоос

гэр цэцэрлэгийн тоо 5-аар нэмэгдсэн бөгөөд 504 хүүхэд хамрагдсан. Статистик мэдээгээр СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо 3659 болж хамран сургалтын цэвэр жин 65.4 хувь буюу өмнөх жилээс 0,1 хувиар ахисан.



“Тогтвортой амьжиргаа 2” төслийн 15,1 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Уул сумын Бэрх багт 20 хүүхдийн цэцэрлэг шинээр барьж ашиглалтанд өгөөд байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу соёл, урлагийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэд ойртуулах зорилгоор аймгийн Хөгжимт драмын театрын барилгыг нийт 3 тэрбум төгрөгийн өртөгөөр барьж байгаа бөгөөд 2009 онд 700.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн ба 2010 онд 1.0 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн.



Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

сумдын соёлын төвийн үйл ажиллагааг дэмжиж хөгжмийн зэмсэг, техник хэрэгслээр хангах ажлыг



үргэлжлүүлэн иргэдэд үйлчлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор 13 сумын соёлын төвүүдийг хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан улс болон орон нутгийн төсвөөс нийт 177234283 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын хүүхдийг сургуульд бүрэн хамруулах, боловсролын үйлчилгээг ойроос хүргэх зорилгоор 640 хүүхдийн сургуулийн барилгыг шинээр барьж эхлүүллээ. Энэхүү барилгын ажлын 50 гаруй хувийг хийгээд байгаа бөгөөд 2011 онд ашиглалтад хүлээж авна.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллаганы хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын дагуу дотуур байрны үйлчилгээг сайжруулан хүүхдийн хоол хүнсний чанар, хангамжийг стандартын түвшинд хүргэх үүднээс аймгийн Засаг даргын захирамжаар сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд хяналт тавих орон тооны бус 9 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулагдан ажиллаж байна. 2010 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гурванзагал сумын сургуулийн дотуур байрны засварт 156 сая, 6 дугаар цэцэрлэгт 15 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж авсан. Орон нутгийн төсвөөр Сэргэлэн сумын сургуулийн дотуур байрны дээвэрт 1.900.000, “Тогтвортой амьжиргаа-2” төслөөс Булган сумын цэцэрлэг, сургуульд тус бүр 5.0 сая төгрөгийн, 14 дүгээр цэцэрлэгт 4 сая төгрөгийн гал тогооны төхөөрөмж нийлүүлээ.

Эрүүл мэндийн талаар:




Аймгийн Засаг даргын зүгээс өөрийн аймгийн тамирчдаа бодлогоор дэмжиж, үйл ажиллагааг нь хэвийн явуулах боломжоор хангах үүднээс Биеийн тамир төвийн барилгыг **барьж эхлүүлсэн бөгөөд** барилгын ажлын явц 90 гаруй хувьтай явагдаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын 2010 оны 34 дугаар захирамжийн дагуу хийн дасгал хөдөлгөөнийг бүх багууд дээр зохион байгуулж хэвшээд байгаа бөгөөд өдөрт дунджаар 250 гаруй иргэн буюу давхардсан 2200 гаруй



иргэн хамрагдсан байна.

Монгол улсын



Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд алслагдсан хөдөө орон нутгийн хүн амд үзүүлэх явуулын эмнэлгийн тусламж, нийгмийн эрүүл мэндийн цогц үйлчилгээг хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор өвчнийг эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс Хөлөнбуйр, Цагаан-овоо, Сэргэлэн сумын эмнэлэгт Эрүүл мэндийн сайдын 2010 оны 111 тоот тушаалаар тус бүр 18.3 сая төгрөгний өртөг бүхий УАЗ 469 автомашин, аймгийн төвийн өрхийн эмнэлгүүдэд 16.5 сая төгрөгний үнэ бүхий Зширхэг Nissan Extral маркийн автомашин, мөн 120 сая төгрөгний үнэ бүхий зайлшгүй шаардлагатай оношлогоо, эмчилгээний болон мэдээ, мэдээллийн тоног төхөөрөмжийг нийлүүлээд байна. Дээрх 3 өрхийн эмнэлгүүдийг цахим сүлжээнд холбох ажлын эхлүүлэх үүднээс G мобайлын интэрнэтийн модемоор хангалаа.

2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн хүүхдийн тасгийн барилгыг 100 сая төгрөгийн өртөгтэйгээр бүрэн засварлаж ашиглалтад орууллаа.



Аймгийн төвийн Хэрлэн сумын 7 дугаар багт улсын төсвийн хөрөнгөөр 180.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 давхар барилгыг ашиглалтад оруулан ард иргэдэд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан үйл ажиллагаа явуулж эхлээд байна

Хөдөлмөр, нийгмийн халамжийн

талаар:

Иргэн бүрт хувь хишиг хүртээх үйл ажиллагаа

“Монгол улсыг хөгжүүлэх сан”-гаас иргэн бүрт хишиг, хувь олгох ажлыг 2 сарын 1-нээс эхэлсэн бөгөөд 6 сарын 30-ны байдлаар нийт 73400 иргэнд 7922399.0 мянган төгрөг олгоод байна.

Мөн 7 сарын 01-нээс эхлэн сар бүр 10.0 мянган төгрөг олгох ажлыг зохион байгуулж 2010 оны жилийн эцсийн байдлаар 37116 иргэний нэр Улсын бүртгэлийн газраас ирж 0-16 хүртлэх насны хүүхэд 20653, нийт 57769 иргэд хишиг хувиа бэлнээр аваад байна.





Ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 1524 иргэн хамрагдаж, ажил олгогчидтой идэвхтэй хамтран ажилласны үр дүнд тус хэлтэст 1540 ажлын байрны захиалга ирснээс 1524 иргэнийг ажлын байранд зуучилснаас 264 иргэнийг байнгын, 414 иргэнийг улирлын, 846 иргэнийг түр ажлын

байранд зуучиллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 505.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж одоогийн байдлаар нийт 181 иргэнд 259.1 сая төгрөгийн зээл олгож, эдгээрийн үр дүнд 333 ажлын байрыг шинээр бий болгосоныг www.ejob.mn вэб сайтад бүртгэж мэдээллээд байна.



Зүүн бүсийн ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах амралт сувиллын “Дорнын сувилал” төв нийт 12 удаагийн ээлжид нийт 400 гаруй ахмадууд амарч Нийгмийн халамжийн сангаас 4759.5 мянган төгрөг, орон нутгын төсвөөс 5.0 сая төгрөг нийт 9759.5 мянган төгрөгийг зарцууллаа.

Ахмадын чөлөөт цагийн төв нь давхардсан тоогоор нийт 1400 гаруй иргэдэд үйлчилгээ /нийтийн бүжиг, шатар даам тоглох, зэрэг/ үзүүлж орон нутгийн төсвөөс нийт 22300.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын талаар:

Аймгийн хэмжээнд Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 6.1 тэрбум төгрөг хуримтлуулахаас 6.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн, 758.0 сая төгрөг буюу төлөвлөгөөг 112.3 хувиар давуулан биелүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2010 онд заавал даатгалд 12931, сайн дурын даатгалд 1655 хүн тус тус хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад заавал даатгалуулагч 275, сайн дурын даатгуулагч 277 хүнээр нэмэгдсэн байна.





Нийгмийн даатгалын тухай багц хуулиар малчид, албан бус секторт ажиллагсад нийгмийн даатгалд сайн дурын үндсэн дээр даатгуулахаар зохицуулжээ. Аймгийн 2009 оны статистикийн мэдээгээр нийгмийн даатгалд хамрагдвал зохих 8501 малчин байгаагийн 2338 малчин эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагджээ.

Аймгийн хэмжээнд иргэний эрүүл мэндийн даатгалд хамрагдвал зохих **52000** хүн амыг хамруулахаас **57023** даатгуулагч хамрагдаж өлөвлөгөөг **109.6** хувиар биелүүлээд байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР